МЭДЭЭ · 2022 оны 3-р сарын 23

ЭРҮҮЛЖҮҮЛЭХ БАЙРНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШАЛГАЖ, ШААРДЛАГА ХҮРГҮҮЛЭХЭЭР БОЛЖЭЭ



Сонгинохайрхан дүүргийн прокурорын газраас тус дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн дэргэдэх эрүүлжүүлэх байрны ахуй нөхцөл, үйл ажиллагааг шалгасан байна.

Шалгалтын явцад согтууруулах ундаа хэрэглэсэн нь тогтоогдсон боловч гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийг эрүүлжүүлсэн, Эрүүлжүүлэх байрны стандарт, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийг нэг мөр хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлүүд илэрч, тус Цагдаагийн хэлтэст прокурорын шаардлага хүргүүлэхээр болжээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2403